



ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХШҮ-ний багийн дарга

Ерөнхий инженер:

/С.Мөнхбат/

Дархан –Уул аймаг
2025 он.

ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.

ҮНДЭСЛЭЛ

Дархан хотын тохижилт үйлчилгээний газар нь Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Дархан-Уул аймгийг 2025-2028 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2025 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрүүдийг бүрэн хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа.

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

/ нийт үнэлгээний 100% буюу 5 оноо/

1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Монгол Улсын хог хаягдлын тухай хуулийн 8 бүлэг 21 зүйл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 1 бүлэг 4 зүйл, Шилэн дансны тухай хуулийн 3 бүлэг 11 зүйл, Засгийн газрын 6 тогтоолын 12 заалт, Аймгийн Засаг даргын 2025 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Дархан сумын ИТХ-ын 2022 оны 15 дугаар тогтоол, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Архивын тухай хууль, Дархан сумын ИТХ –ын тогтоолуудын холбогдох заалтуудыг хяналтанд авч хэрэгжилтийг хангуулан ажилласнаар холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэнд ХШҮ хийсэн дүнгээр 2025 оны жилийн эцсийн байдлаар 98%-ийн хэрэгжилттэй 4,9 онооны үнэлгээтэй байна.

1.2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.

..... хамааралгүй.....

1.3. Дархан сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт .

Үндсэн чиглэлийн 5 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж байгууллагын 100%-ийн хэрэгжилтэй 5,0 онооны үнэлгээтэй байна.

1.4. Дархан сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Дархан сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 бүлэг, 9 зорилт, 21 дэд бүлэг, 43 зорилт, 165 арга хэмжээнээс

1.3. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ХАМГААЛАЛ.

2025 онд Хүүхэд хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Газрын даргын тушаалаар 2025 онд Хүүхэд хөгжлийн сан, Эцэг эхийн зөвлөл байгуулж багийн гэр бүлийн хөгжил хамгаалал хариуцсан нийгмийн ажилтануудтай хамтран ажиллаж байна.

1.3.2.2 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд

Тус байгууллага нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 7 ахмад ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй 5 хүнийг тус тус ажлын байраар ханган ажиллаж байна.

1.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.4.1.3 Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ

1.4.1.6 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

2024 оноос ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд 15-20 ахмадыг жил ногоон байгууламжийн ажилд 2-3 сарын хугацаатай хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллаж байна.

2.1 ХҮН ТӨВТЭЙ ХОТ

2.1.2 Инженерийн дэд бүтцийг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Дархан хотын хэмжээнд нийт 61,812ш гэрэл гэрэлтүүлэгийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Энэ онд 819ш гэрэл гэрэлтүүлэг хүлээн авч засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

2.1.2.5 Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.

2.1.3 Авто замын сүлжээг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.3.1 Хотын доторх авто зам, замын байгууламж, явган хүний болон дугуйн зам, авто зогсоолыг өргөтгөн, шинэчилж, нэвтрэх чадвар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Дархан хотын хэмжээнд авто, явган, дугуйн замын 934,112 м2 замын цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан хотын иргэдийн цэвэр эрүүл аюулгүй орчин бүрдүүлэн ажиллаж байна.

2.1.4 Нийтийн зориулалттай орон сууцны ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.

2.1.4.3 Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, засвар, шинэчлэлт, арчлалт хамгаалалтыг сайжруулж хортон шавжийг устгах ажлыг хэрэгжүүлнэ.

Орон сууц, гэр хороолол дунд байрлах 66 жишиг хорооллийн тоглоомын талбайд засвар үйлчилгээ хийхэд 200,000 сая төгрөг зарцуулж өнгө үзэмжийг нэмэгдүүлсэн.

2.2 НОГООН ХОТ

2.2.1 Хүрээлэн буй орчныг хамгаалж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

2.2.1.4 Үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан усыг дахин ашиглах технологийг хөгжүүлж, “Саарал ус”-ны хэрэглээг үе шаттайгаар нэмэгдүүлэхийг дэмжинэ. 2025 онд 489 рейс буюу 2445 тн усаар нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгааг хийж ажилсан. Ногоон байгууламж жил

2.2.1.5 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Дархан-2032” хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах, хамгаалах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Дархан хотын нийтийн эзэмшлийн 11 байршилд 15980 мкв талбайд зүлэгжүүлэлт 4 байршилд 4 төрлийн 2442 ширхэг мод бутыг шинээр болон нөхөн тарилтаар тарьсан байна. Мөн нийтийн эзэмшлийн талбайд таригдах 200000 мянган ширхэг мандлын цэцэг тарьж Дархан сумын нийтийн эзэмшлийн талбайд таригдаж дархан хотын өнгө үзэмжийг сайжруулсан Жил бүр хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилго тавьж ажиллаж байна.

3.1 ТӨСӨВ САНХҮҮ

3.1.1 Төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулна.

3.1.1.1 Төсвийн сахилга батыг чанд сахиж, төсвийн хяналтыг сайжруулна.

3.1.1.2 Төсөв, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулна.

3.1.1.3 Төсвийн ил тод байдлыг ханган ажиллана.

3.1.2 Төсөл, тендер, сангуудаас олгох зээлийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод, нээлттэй явуулна.

3.1.2.1 Тендер шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээний хороонд ажиллах хараат бус гишүүнийг цахим систем ашиглан сонгож, ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.

3.1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

Байгууллагын хэмжээнд бүртгэлтэй үндсэн болон эргэлтийн хөрөнгийн жилд 2 удаа тооллого зохион байгуулж эд хариуцагч тус бүрт шилжүүлэн эд хөрөнгө бүрэн хариуцалгийн гэрээ хийж ажиллаж байна.

3.1.3.1 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулж, санхүүгийн хараат бус байдлыг дэмжиж ажиллана.

3.5.1.4 Мал нэвтрэхийг хориглох бүс нутгийг тогтоож, мөрдөх журмыг батлуулж хэрэгжилтийг хангана.

Дархан сумын ИТХ ын 2021 оны 64 дүгээр тогтоолийн дагуу Мал нэвтрэхийг хориглосон нутаг дэвсгэрийн бүсчлэл тогтоох мөрдөх журамын дагуу 1512 малыг хашиж торгуул ноогдуулсан байна.

3.5.1.5 Хотын төвөөс мал, туслах аж ахуйг гаргах ажлыг үргэлжлүүлнэ
Хэрэгжилт 100 хувийн биелэлтэй 5 онооны үнэлгээтэй дүгнэгдэв.

1.5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

..... хамааралгүй

/ хүрээнд хэдэн зорилтын хэдэн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, ямар үнэлгээтэй байгаа, тайланг дээд шатны байгууллагатаа хүргүүлсэн албан бичгийн огноо зэргийг тусгаж 1-3 өгүүлбэрт багтааж бичнэ/

Хоёр. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

/ нийт үнэлгээний 100% 5 оноо/

2.1.Сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.

Дархан хотын тохижилт үйлчилгээний газрын дарга Дархан сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 6 зорилт 54 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Үүнд:“Зорилт-1:Хүний нөөцийн цогц бодлогыг бий болгож, бүтээмжийг сайжруулах”

“Зорилт-2: Нягтлан бодох бүртгэл, төсвийн ил тод байдлын талаар

“Зорилт-3:Дархан хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх”,

“Зорилт-4:Дархан хотын зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ сайжруулах, ард иргэдийг цэвэр, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх”,

“Зорилт-5: Дархан хотын гэрэл, гэрэлтүүлэгийн ашиглалтыг сайжруулах, эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх, хэмнэх”,

“Золбин нохой, муур устгал” Жишиг хорооллын арчилгаа үйлчилгээ, үерийн далан суваг, үржүүлгийн талбайн үйл ажиллагааны хэвийн ажиллагааг хангуулж 98,0%-ийн биелэлттэй 4,9 оноотой ханган ажилласан байна.

2.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд

2025 оны 03 дугаар сарын 25-ний өдөр Төрийн албаны Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичиг А.Лхагважаргал Төрийн албан хаагчийн ёс зүйн харилцаа хандлага сэдвээр сургалт мэдээллийг нийт инженер техникийн 15 ажилтанд сургалт орсон.

Монголын дотоод хяналт эрсдлын удирдлагын хөгжил холбооноос зохион байгуулсан Эрсдлийн бодлогын бичиг баримт боловсруулах анхан шатны ойлголт авч хэрэгжүүлхийн тулд байгууллагын удирдлагыг Эрсдлийг тодорхойлж удирдах арга зүйн сургалт, Дотоод хяналт шалгалт хийх арга зүйн сургалтанд хамруулан ажиллсан

Гурав. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

/ нийт үнэлгээний 100 % 5 оноотой/

3.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль-д заасны дагуу байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажиллаж байна.

Мөн холбогдох мэдээлэлийг **darkhan-hot-tohijilt.mn** домэйн нэртэй веб хуудсанд болон ил тодын самар дээр мэдээлүүдийг оруулан ажиллаж байна.

Байгууллагын ил тод байдлын хэрэгжилт 100%-ийн биелэлттэй 5,0 үнэлгээтэй дүгнэгдлээ.

3.2.Шилэн дансны хөтлөлтийн талаар:

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 158 мэдээлэл байршуулахаас 158 мэдээлэл байршуулж 1-3 дугаар улирлын байдлаар цахимаар хуулийн хугацаанд нь илгээсэн. Гүйцэтгэлтэй 100% -ийн 5 оноотой үнэлэгдэж байна.

3.3.Шударга байдлын түвшний үнэлгээ.

3.4.Хэрэглэгчийн үнэлгээ.

Дархан хотын тохижилт үйлчилгээний газраас хэрэглэгчидээс сэтгэл ханамжийн судалгааг авсан. Үүнд

- 1.Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ.
- 2.Байгууллагын үндсэн үйл ажиллагаа
- 3.Ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа

Хэрэглэчийн үнэлгээг гаргахдаа 5 асуултаар 3 удаа давхардсан тоогоор 400 иргэнийг хамруулж судалгаа гарган даргын зөвлөл дээр соносж хийх ажилдаа тусган дүнг тооцож 100%-ийн гүйцэтгэлтэй 5 оноотой үнэлэгдэж байна.

ДӨРӨВ. ТЭРГҮҮН ТУРШЛАГА, ОНЦЛОГ АЖИЛ.

Тухайн жилд нийтэд үлгэр жишээ болсон ажил үйлчилгээ, гарсан үр дүн үр нөлөөний талаар бичих.

4.1.Оны онцлох ажлууд: Ногоон Дархан 2032 хөтөлбөрийн хүрээнд Дархан сумын хэмжээнд энэ онд 15,980 кв ногоон байгууламжийг шинээр нэмэгдүүлж ногоон байгууламжийн арчилгаа цэвэрлэгээг хариуцан ажиллаж байна. Энэ онд Хуульчдын гудамж 5320 кв, "Ардын өргөн чөлөө" гудамж буюу Дархан сумын 8, 9, 12, 14-р багийн 5218кв,13 дугаар баг "Бурхантын гудамж"-д 700м.кв, Олимпийн гудамжинд 3000мкв ,

Бурхантын гудамжинд 1742мкв, Нийт 15980 м.кв талбайг зүлэгжүүлэн ногоон байгууламж нэмэгдүүлэн ажиллалаа.

Мөн мод тарилтаар 116ш нарс, 1850ш хайлаас, 105ш агч, 371ш гацуур нийт 2442ш мод тарьж усалгааг арчилгаа хийж байна. Хүрээлэн буй орчны өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор 200,000 ширхэг мандлын цэцгийг бойжуулж тарилт хийж хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэн ажиллалаа.

4.2 Дархан хотын нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 61812 гэрэл гэрэлтүүлэгт үзлэг үйлчилгээг тогтмол хийж мөн дуудлагаар ирсэн 71 байрлалд гэмтэл доголдолд 253 байрлалд үзлэг үйлчилгээ хийж гэрэл гэрэлтүүлгийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.

Мөн Дархан хотын авто замын 14 уулзварын гэрлэн дохионд ажлын горимыг тохируулж, үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

2025 онд нийт 27 удаагийн цагийн тохиргоог байгалийн гэрэлтүүлэгтэй уялдуулан хийж авто замаар зорчигч болон иргэдийн аюулгүй байдлыг ханган, эрчим хүчний хэмнэлт гарган ажилласан.

2025 оны 4 дүгээр сарын 14-16-ны хооронд үндсэн болон туслах зам дээр байрлалтай 218ш шүүлтүүр худгуудад үзлэг шалгалт хийхэд 66 шүүлтүүр хэвийн 152 худгийн хог шороог цэвэрлэж, 34ш худгийн шүүлтүүр эвдэрсэн байсны засаж хэвийн болгосон.

4.4 Аймгийн хөрөнгө оруулалтаар жишиг хорооллын засварт 200 сая төгрөгийн бараа материалыг тендер ялсан ААНБ-аас авч 66 байршилд засвар үйлчилгээ хийж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх өнгө үзэмжийг сайжруулан ажиллалаа. Үүнд

1. Гулсууртай олон талт тоглоом - 10
2. Олстой тоглоом - 12
3. Сандаал - 31
4. Хогын сав - 20
5. Самбар - 2
6. Кольцо - 7
7. Палк – 4
8. Самбарны татуурга – 2
9. Гулсуур хос – 1
10. Дан гулсуур – 1

Савлуур гинжтэй 5 эдгээр тоглоомууд шинээр суулгаж, 5 сагсны талбайн тор бүтэн шинэчилэн сольж, 23 сагсны талбайн тор нөхөж сэргээн засаж 61 саравчны дээвэр засварлаж нөхөж шинэчилэн засварлаж засваруудыг хийж гүйцэтгэсэн.

Тав. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛУУД:

5.1. Дархан сумын нутаг дэвсгэрт ургаж байгаа харшлын шинж чанартай өвчин үүсгэгч хог ургамлын төрөл зүйл овгийг судлан гербцид хорийг сонгон шарилж устгалыг жилд 6,7,8 дугаар саруудад хийж байна.

Зургаа. ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД

6.1. Дархан хотын авто зам нэмэгдэж байгаатай холбоотой авто зам шүүрдэх болон цас цэвэрлэх 1ш автомашин.

6.2. Ногоон байгууламж услах усалгааны 1ш автомашин.

ТАНИУЦАН:
ДХТҮГ-Н ДАРГАЗ.ЭРДЭНЭБАТ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН
ДАРГА:С.МӨНХБАТ

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ГИШҮҮД
ЕРӨНХИЙ НЯГТЛАН Б.МӨНХЦЭЦЭГ
ТОХИЖИЛТЫН ИНЖЕНЕР Д.ЭНХТУЯА
ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР Б.ОКТЯБРЬ

**ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН.**

(2025 он)

(2020-01)

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	98,0	0,6	
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	-		
	3.Аймаг нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	100		
	4.Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100		
	5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	100		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	97,6	0.2	
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	100		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	0.4	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	94		
Ерөнхий үнэлгээ:		99,0%	1.0	

ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР .